

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

---

**Төмөр замын зорчигч тээврийн үйлчилгээ. Зорчигчийн галт тэрэг, вагон дахь  
үйлчилгээний ерөнхий шаардлага**

**MNS 5876:2023**

**Албан хэвлэл**

**Стандарт, хэмжил зүйн газар  
Улаанбаатар хот  
2023 он**

## АГУУЛГА

1	Хамрах хүрээ.....	1
2	Норматив эшлэл .....	1
3	Нэр томъёо, тайлбар.....	2
4	Зорчигчийн галт тэрэг, вагоны ангилал, зэрэглэл .....	3
4.1	Зорчигчийн галт тэрэгний ангилал.....	3
4.2	Зорчигчийн вагоны зэрэглэл.....	4
4.3	Зорчигчийн галт тэрэг, вагон дахь үйлчилгээний ангилал .....	4
5	Зорчигчийн галт тэргэнд тавих шаардлага .....	4
5.1	Ерөнхий шаардлага.....	4
5.2	Зорчигчийн вагонд тавих шаардлага .....	5
5.3	Зорчигчийн зүтгүүрт тавих шаардлага.....	5
5.4	Моторт вагонд тавих шаардлага .....	5
5.5	Олон улсын харилцааны галт тэргэнд тавих шаардлага.....	5
5.6	Тусгай үйлчилгээний галт тэргэнд тавих нэмэлт шаардлага .....	5
5.7	Төвлөрсөн цахилгаан хангамжтай болон олон үүсгүүртэй галт тэргэнд тавих нэмэлт шаардлага.....	5
5.8	Аяллын чиглэлийн мэдээлэл ба суух дугаарт тавих шаардлага.....	5
6.	Зорчигчийн галт тэрэгний ажилтанд тавих шаардлага .....	6
6.1	Нийтлэг шаардлага .....	6
6.2	Үндсэн чиг үүргийн ажилтанд тавих шаардлага.....	7
6.3	Туслах чиг үүргийн ажилтанд тавих шаардлага.....	7
6.4	Галт тэрэгний ажилтнуудын хувцас, хувцаслалт ба гоо зүйд тавих шаардлага.....	7
7.	Зорчигчийн галт тэрэгний аяллын бэлэн байдалд тавих шаардлага .....	10
7.1	Техникийн бэлэн байдалд тавих шаардлага .....	10
7.2	Үйлчилгээний бэлэн байдалд тавих шаардлага.....	10
7.3	Зэхэлтийн материал хэрэгсэлд тавих шаардлага.....	11
8	Зорчигчийн галт тэрэг, вагон дахь үйлчилгээнд тавих шаардлага.....	15
8.1	Ерөнхий шаардлага.....	15
8.2	Зорчигч, үйлчлүүлэгчийг угтан авах, үдэн гаргах.....	15
8.3	Зорчигчдод үйлчлэх .....	16
8.4	Зорчигчдын ая тухыг хангах.....	16
8.5	Зорчигчийн вагоны аяллын үеийн цэвэрлэгээ, халдваргүйтгэл.....	16
8.6	Мэдээллийн үйлчилгээ.....	17
8.7	Вагон ресторан, хүнсний худалдаа үйлчилгээ .....	21

8.8	Тээш тээвэрлэх үйлчилгээ .....	21
8.9	Аяллын үед зорчих тасалбараар үйлчлэх .....	21
Ном зүй	.....	22

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 45.020

<b>Төмөр замын зорчигч тээврийн үйлчилгээ. Зорчигчийн галт тэрэг, вагон дахь үйлчилгээний ерөнхий шаардлага.</b>	<b>MNS 5876:2023</b>
<b>The service of railway passenger transport. General requirement for services in the passenger train and carriage of railway.</b>	<b>MNS 5876:2012-ын оронд</b>

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны ... дугаар сарын ... –ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь 2023 оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн мөрдөнө.

## 1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь төмөр замын зорчигч тээврийн үйл ажиллагааны зорчигчийн галт тэрэг, вагон дахь үйлчилгээнд тавих шаардлага, хэм хэмжээг тогтооно.

## 2 Норматив эшлэл

Энэ стандартад дараах баримт бичгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн эш татсан болно. Он заасан баримт бичгийн хувьд зөвхөн тухайн хэвлэлийг, он заагаагүй бол хүчинтэй хэвлэлийг хэрэглэнэ.

MNS 6312:2012, *Төмөр замын зорчигчийн вагон. Техникийн ерөнхий шаардлага*  
MNS 6466:2023, *Вагоны техникийн үзлэг, үйлчилгээ, засвар. Техникийн шаардлага*

MNS 6039:2020, *Илчит тэрэг. Техникийн ерөнхий шаардлага*

MNS 4585:2016, *Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага*

MNS 4946:2019, *Хоолны үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага*

MNS 5007:2022, *Савласан ус. Техникийн ерөнхий шаардлага*

MNS 0687-1:2012, *Төрөл бүрийн жимс жимсгэнэ, ногооны шүүс. Техникийн ерөнхий шаардлага*

MNS 0687-2:2014, *Үл согтууруулах ундаа. Цай болон кофены төрлийн ундаа. Техникийн ерөнхий шаардлага*

MNS 0687-3:2015, *Хийжүүлсэн ундаа. Техникийн шаардлага*

MNS 0900:2018, *Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ*

MNS 1804:2006, *Хагас боловсруулсан махан бүтээгдэхүүн. Техникийн ерөнхий шаардлага*

MNS 5644:2006, *Олон нийтийн болон үйлдвэрлэлийн барилгын хуваарилах самбар. Техникийн ерөнхий шаардлага*

MNS 5679:2022, *Сайжруулсан хатуу түлш. Техникийн шаардлага*

MNS 6780:2019, *Дулаан хуримтлуурт цахилгаан халаагуур. Техникийн ерөнхий шаардлага*

MNS 6853:2020, *Эрүүл мэндийн зориулалттай нэг удаагийн халдвар хамгааллын хэрэгсэл. Комбинзон болон гутлын гадуур өмсгөлийн иж бүрдэл. Техникийн шаардлага*

MNS 6955:2021, *Байгалийн эрдэст ус. Техникийн ерөнхий шаардлага*  
MNS ISO 9001:2016, *Чанарын менежментийн тогтолцоо. Шаардлага*  
MNS ISO 22000:2019, *Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо.*  
*Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид тавих шаардлага*  
MNS ISO 13688:2000, *Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй.*  
*Хамгаалалтын хувцас - Ерөнхий шаардлага*

### **3 Нэр томьёо, тайлбар**

#### **3.1**

##### **ажлын тал**

зорчигчийн вагоны хяналт удирдлагын өрөө байрлах уртын дагуух хагас

#### **3.2**

##### **аяллын чиглэл**

зорчигчийн галт тэрэг хаанаас хаа хүрэх, хааш буцах тухай мэдээлэл

#### **3.3**

##### **дайгуул галт тэрэг**

аяллын явцад үндсэн галт тэрэгнээс салж аялах галт тэрэг

#### **3.4**

##### **зорчигч**

зорчих тасалбартайгаар зорчигчийн галт тэргээр аялж буй хүн

#### **3.5**

##### **зорчигч тээврийн байгууллага**

зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй төмөр замын байгууллага эсвэл түүний зохион байгуулалтын нэгж

#### **3.6**

##### **зорчигч тээврийн үйл ажиллагаа**

зорчигчийн галт тэргээр зорчигч, тээш тээвэрлэх үйлчилгээ

#### **3.7**

##### **зорчигчийн вагон**

зорчигч тээвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд зориулагдсан зохих тоноглол бүхий хөдлөх бүрэлдэхүүний нэгж

#### **3.8**

##### **зорчигчийн галт тэрэг**

зүтгүүр ба зорчигчийн вагонуудаас бүрдсэн галт тэрэгний бүрэлдэхүүн

#### **3.9**

##### **зэхэлт (зэхэх)**

зорчигчийн галт тэрэг, вагоныг шаардагдах материал хэрэгслээр хангах үйл ажиллагаа

#### **3.10**

##### **контент**

тодорхой агуулгын хүрээнд дүрс, дуу, бичвэр байдлаар хэрэглэгчид хүрч буй мэдээлэл

### **3.11**

#### **мөрийн урт**

хүрэх газрын алслалт буюу явах ирэх нийт замын хагас

### **3.12**

#### **тасалбар (зорчих тасалбар)**

зорчигчийн галт тэргээр зорчих эрхийн нотолгоо

### **3.13**

#### **төмөр замын байгууллага**

төмөр замын тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд

### **3.14**

#### **тээш**

зорчигчийн зорчих тасалбарыг үндэслэн тээшийн вагоноор тээвэрлэж буй эд юмс

### **3.15**

#### **унд**

уух зориулалт бүхий шингэн зүйл (цай, кофе, жүүс, ундаа гэх мэт)

### **3.16**

#### **хөдлөх бүрэлдэхүүн**

зорчигчийн галт тэргийг бүрдүүлж буй зүтгүүр, вагон

### **3.17**

#### **чиглэлийн самбар**

зорчигчийн галт тэрэг хаанаас хаа хүртэл аялахыг заасан самбар

## **4 Зорчигчийн галт тэрэг, вагоны ангилал, зэрэглэл**

### **4.1 Зорчигчийн галт тэрэгний ангилал**

#### **4.1.1 Харилцааны төрлөөр нь:**

- a) Олон улсын харилцааны (2 ба дээш улсын нутаг дэвсгэрийг дайран аялдаг);
- b) Орон нутгийн (Монгол улсын нутаг дэвсгэрийн хүрээнд аялдаг).

#### **4.1.2 Аялж буй мөрийн уртаар нь:**

- a) Алсын аяллын (700 км-ээс дээш);
- b) Хот хоорондын (700 км хүртэлх);
- c) Хот дүүргийн (хотын доторх).

#### **4.1.3 Шилжих аргаар нь:**

- a) Зүтгүүрийн таталттай;
- b) Моторт вагон.

#### **4.1.4 Цахилгаан үүсгүүрээр нь:**

- a) Төвлөрсөн цахилгаан хангамжтай;
- b) Бие даасан (тус тусын) цахилгаан үүсгүүртэй;
- c) Олон үүсгүүртэй.

**4.1.5 Аяллын давтамжаар нь:**

- a) Байнгын аяллын;
- b) Нэмэгдэл аяллын (тодорхой хугацааны интервалд тогтмол графикаар аялах);
- c) Нэг удаагийн аяллын.

**4.1.6 Аяллын хэлбэрээр нь:**

- a) Бие даасан аяллын галт тэрэг;
- b) Дайгуул галт тэрэг.

**4.1.7 Хэрэглэгчээр нь:**

- a) Нийтийн үйлчилгээний – нийтэд үйлчлэх;
- b) Тусгай үйлчилгээний:
  - 1) Төрийн үйлчилгээний – төрийн өндөр албан тушаалтан аялах;
  - 2) Дотоод үйлчилгээний – байгууллагын өндөр албан тушаалтан аялах;
  - 3) Захиалгат үйлчилгээний – үйлчлүүлэгчийн урьдчилсан захиалгын дагуу аялах;

**4.2 Зорчигчийн вагоны зэрэглэл**

Зорчигчийн вагоныг түүний зориулалт, хийцийн ба үйлчилгээний онцлогоос хамаарч дараах түвшнүүдэд зэрэглэн авч үзнэ. Үүнд:

- a) Дээд зэрэглэл буюу “тусгай вагон” – тусгай үйлчилгээний, тусгай зориулалтын болон албан хэрэгцээний (цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлтэй);
- b) Тохилог зэрэглэл буюу “зөөлөн вагон” – зорчигчийн тасалгаануудтай, нэг тасалгаанд 2 зорчигч хүлээн авах (цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлтэй);
- c) 1-р зэрэглэл буюу “тасалгаат вагон” – зорчигчийн тасалгаануудтай, нэг тасалгаанд 4 зорчигч хүлээн авах (цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлтэй);
- d) 2-р зэрэглэл буюу “унтлагын вагон” – зорчигчийн нээлттэй таславчуудтай (цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлтэй);
- e) 3-р зэрэглэл буюу “нийтийн вагон” – зорчигчийн нээлттэй таславчуудтай, суугаа аялах;
- f) Моторт вагон – хөдөлгүүр бүхий зорчигчийн вагон.

**4.3 Зорчигчийн галт тэрэг, вагон дахь үйлчилгээний ангилал**

Зорчигчийн галт тэрэг, вагон дахь үйлчилгээг түүний төрөл ба цар хэмжээгээр нь дараах байдлаар ангилан авч үзнэ. Үүнд:

- a) Үндсэн үйлчилгээ – зорчигч тээврийн байгууллагаас тогтоосон суурь үйлчилгээ;
- b) Нэмэлт үйлчилгээ – зорчигч тээврийн байгууллагаас тогтоосон бусад үйлчилгээ;
- c) Тусгай үйлчилгээ – төмөр замын байгууллагаас тогтоосон тусгай үйлчилгээ;
- d) Тансаг үйлчилгээ – хэрэглэгчийн захиалгын дагуу үзүүлэх “Premium” үйлчилгээ.

**5 Зорчигчийн галт тэргэнд тавих шаардлага****5.1 Ерөнхий шаардлага**

Зорчигчийн галт тэрэг нь Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан төмөр замын техник ашиглалтад хамаарах дүрэм, журмуудад заасан шаардлагуудад бүрэн нийцсэн байна.

## **5.2 Зорчигчийн вагонд тавих шаардлага**

**5.2.1** Зорчигчийн галт тэргэнд аялах вагонууд нь “MNS 6312. Төмөр замын зорчигчийн вагон. Техникийн ерөнхий шаардлага” стандартад нийцсэн байна.

**5.2.2** Зорчигч тээврийн байгууллага нь зорчигчийн вагонуудыг “MNS 6466. Вагоны үечилсэн техникийн үзлэг, үйлчилгээ ба засвар. Ерөнхий шаардлага” стандартад заасны дагуу техникийн үзлэг, үйлчилгээ ба засварт хамруулж баримтжуулсан байна.

## **5.3 Зорчигчийн зүтгүүрт тавих шаардлага**

Зорчигчийн зүтгүүр нь “MNS 6039. Илчит тэрэг. Техникийн ерөнхий шаардлага” стандартад нийцсэн байна.

## **5.4 Моторт вагонд тавих шаардлага**

Зорчигч тээвэрлэх моторт вагон нь “ГОСТ Р 54750. Рельсовые автобусы. Общие технические требования” стандартад нийцсэн байна.

## **5.5 Олон улсын харилцааны галт тэргэнд тавих шаардлага**

Олон улсын харилцааны галт тэрэг нь тухайн цаг мөчид хүчин төгөлдөр үйлчилж буй олон улсын зорчигч тээврийн тухай баримт бичгүүдэд нийцсэн байна.

## **5.6 Тусгай үйлчилгээний галт тэргэнд тавих нэмэлт шаардлага**

Төмөр замын байгууллага нь тусгай үйлчилгээний галт тэргэнд тавих нэмэлт шаардлагыг тодорхойлж хангуулан ажиллана.

## **5.7 Төвлөрсөн цахилгаан хангамжтай болон олон үүсгүүртэй галт тэргэнд тавих нэмэлт шаардлага**

**5.7.1** Төвлөрсөн цахилгаан хангамжтай галт тэрэгний цахилгаан хуваарилах самбар нь “MNS 5644. Олон нийтийн болон үйлдвэрлэлийн барилгын хуваарилах самбар. Техникийн ерөнхий шаардлага”, халаалтын төхөөрөмжүүд нь “MNS 6780:2019. Дулаан хуримтлуурт цахилгаан халаагуур. Техникийн ерөнхий шаардлага” стандартуудаар тогтоосон шаардлагуудыг хангасан байна.

**5.7.2** Олон үүсгүүртэй буюу өндөр хүчдэлд холбогдон аялах галт тэрэгний цахилгаан ба халаалтын систем нь “ГОСТ 33596–2015. Устройства электронагревательные для систем отопления железнодорожного подвижного состава” стандартаар тогтоосон шаардлагуудыг хангасан байна.

## **5.8 Аяллын чиглэлийн мэдээлэл ба суух дугаарт тавих шаардлага**

### **5.8.1 Аяллын чиглэл**

Зорчигчийн галт тэрэгнүүд нь тус тусын аяллын чиглэлийг зорчигчийн тавцангаас тодорхой харагдахуйц байрлалд буюу зорчигчийн вагон нэг бүрийн ажлын талын эхний том цонхны дотор талд чиглэлийн самбар дээр дараах шаардлагад нийцүүлэн байршуулсан байна. Үүнд:

а) Тухайн галт тэрэгний аяллын чиглэлийг дараах байдлаар томъёолсон байх:

ХААНААС – ХАА ХҮРЭХ – ХААШ БУЦАХ



- b) Орон нутгийн галт тэрэгний чиглэлийн самбар нь зөвхөн Монгол хэлээр байна;
- c) Олон улсын харилцааны галт тэрэгний чиглэлийн самбар нь Монгол, Англи ба тухайн улсын хэлээр, гурван улс дайрч аялдаг бол тухайн 3 улсын хэлээр бичигдсэн байх ба үндсэн бичвэр нь Монгол хэлээр байна;
- d) Чиглэлийн самбарын бичвэрийг гэрэлтэй, харанхуй аль ч нөхцөлд зорчигч, үйлчлүүлэгчдэд харагдахуйц байдлаар шийдвэрлэсэн байх ба үндсэн бичвэр нь "Impact" төрлийн 12 см-аас багагүй өндөртэй тигээр бичигдсэн, бусад бичвэр нь үндсэн бичвэрийн өндрийн 50%-аас намгүй байна.

## **5.8.2 Суух дугаар**

**5.8.2.1** Суух дугаар нь тухайн галт тэрэгний бүрэлдэхүүн дэх вагоны байршлыг илэрхийлнэ.

**5.8.2.2** Төмөр замын байгууллага нь галт тэрэгний бүрэлдэхүүн дэх вагонуудыг дараах шаардлагад нийцүүлэн дугаарлана. Үүнд:

- a) Вагоны үндсэн дугаар нь зорчигчийн зүтгүүр талаас өсөх эсвэл буурах эрэмбээр дараалсан араб тоо байна;
- b) Аяллын явцад галт тэрэгний бүрэлдэхүүний эхэн ба дунд байнгын аяллын дайгуул галт тэрэг холбогддог нөхцөлд тэдгээрийн дугаарыг алгасч олгосон байна;
- c) Цаг үеийн шийдвэрээр нэг удаагийн болон нэмэгдэл аяллын галт тэрэг, вагон холбох нөхцөлд бүрэлдэхүүний эхэнд нэг вагон холбох бол "0" дугаарыг, хэд хэдэн вагон холбох бол "0-1", "0-2", "0-3" гэх мэт тодотгол бүхий загвараар нэмж дугаарлана. Бүрэлдэхүүний дунд хэсэгт вагон нэмж холбох нөхцөлд өмнөх вагоны дугаарын ард мөн адил тодотголыг нэмж (8-1, 8-2 гэх мэт) дээрхийн адил дугаарласан байна.

**5.8.2.3** Суух дугаарыг зорчигчийн тавцангаас тодорхой харагдахуйц байрлалд буюу зорчигчийн вагоны ажлын талын цонхны дотор талд бие даасан самбар байдлаар эсвэл чиглэлийн самбарын хамт байршуулсан байна.

**5.8.2.4** Суух дугаар нь "Impact" төрлийн 16 см-аас багагүй өндөртэй тигээр бичигдсэн байна.

## **6. Зорчигчийн галт тэрэгний ажилтанд тавих шаардлага**

### **6.1 Нийтлэг шаардлага**

**6.1.1** Зорчигчийн галт тэрэгний ажилтнуудыг чиг үүргээр нь дараах байдлаар ангилан авч үзнэ. Үүнд:

- a) Үндсэн чиг үүргийн ажилтан:
  - 1) Ажил удирдагч - Зорчигчийн галт тэргийг хариуцан ажиллах чиг үүрэг бүхий удирдах ажилтан;
  - 2) Үйлчилгээний ажилтан - Зорчигчдод үндсэн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ажилтан;
  - 3) Цэвэрлэгээний ажилтан - Зорчигчийн вагоны эрүүл ахуй, ариун цэврийг хангах чиг үүрэг бүхий ажилтан;
  - 4) Галлагааны ажилтан - Зорчигчийн вагоны галлагаа хариуцсан ажилтан;

- 5) Техникийн ажилтан - Зорчигчийн вагоны техникийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг хариуцсан ажилтан;
  - 6) Тээшийн ажилтан - Тээш, ачаан тээш, илгээмжийн хүлээн авалт, тээвэрлэлт, түгээлт хариуцсан ажилтан.
- b) Туслах чиг үүргийн ажилтан:
- 1) Тасалбарын ажилтан;
  - 2) Зоогийн вагоны ажилтан;
  - 3) Үүргийн худалдаа үйлчилгээний ажилтан;
  - 4) Захиалгат үйлчилгээ хариуцсан ажилтан;
  - 5) Хамгаалалтын ажилтан;
  - 6) Хяналтын ажилтан;
  - 7) Бусад чиг үүргийн ажилтан.

**6.1.2** Галт тэрэгний ажилтан нар нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна. Үүнд:

- a) Эрхэлж буй ажил үүргийн чиглэлээр мэргэшсэн буюу эрхийн үнэмлэхтэй байх;
- b) Харилцааны ур чадвар эзэмшсэн болохыг нотолсон байх;
- c) Багаар ажиллах чадвартай болохыг нотолсон байх;
- d) Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байх;
- e) Эрүүл мэндээр тэнцсэн байх;
- f) Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, хөтөлбөрт хамрагдсан болохыг баримтжуулсан байх.

## **6.2 Үндсэн чиг үүргийн ажилтанд тавих шаардлага**

**6.2.1** Үндсэн чиг үүргийн ажилтан нар нь тус тусын чиг үүрэгт хамаарах техникийн шалгалтад хамрагдаж тэнцсэн байх бөгөөд шалгалтын үр дүн нь хүчинтэй байна.

**6.2.2** Төмөр замын байгууллага нь үндсэн чиг үүргийн ажилтанд тавих шаардлагыг галт тэрэгний аялж буй мөрийн урт, харилцааны төрөл, хэрэглэгч, шилжих арга, цахилгаан үүсгүүр, аяллын давтамж ба хэлбэрээс хамаарч тус тусын онцлогт нийцүүлэн тодорхойлж албажуулан мөрдүүлнэ.

## **6.3 Туслах чиг үүргийн ажилтанд тавих шаардлага**

Төмөр замын байгууллага нь туслах чиг үүргийн ажилтанд тавих шаардлагыг энэ стандартад заасан чиг үүрэг тус бүрээр тодорхойлж албажуулан мөрдүүлнэ.

## **6.4 Галт тэрэгний ажилтнуудын хувцас, хувцаслалт ба гоо зүйд тавих шаардлага**

### **6.4.1 Ерөнхий шаардлага**

**6.4.1.1** Галт тэрэгний ажилтнуудын хувцас, хувцаслалт, гоо зүй нь тэдний хүйс, чиг үүрэг, ажлын онцлог, улирлын, цаг агаарын болон өдөр шөнийн нөхцөл байдалд тохирсон байх бөгөөд албан тушаалын зэрэг дэвийг илэрхийлэх тэмдэг, тэмдэглэгээтэй байна.

**6.4.1.2** Төмөр замын байгууллага нь галт тэрэгний ажилтнуудын хувцасны загвар ба чанар, хувцаслалт, гоо зүйд тавих шаардлагыг энэ стандартад нийцүүлэн тодорхойлж албажуулан хэрэглэнэ.

#### **6.4.2 Галт тэрэгний ажилтны хувцсанд тавих шаардлага**

**6.4.2.1** Галт тэрэгний ажилтны хувцсыг дараах байдлаар ангилан авч үзнэ. Үүнд:

a) Зорчигч үйлчилгээний:

1) Эрэгтэй:

- Зуны;
- Хавар намрын;
- Өвлийн.

2) Эмэгтэй:

- Зуны;
- Хавар намрын;
- Өвлийн.

b) Цэвэрлэгээний:

1) Эрэгтэй;

2) Эмэгтэй.

c) Галлагааны:

1) Дулаан;

2) Хөнгөн.

d) Техник үйлчилгээний:

1) Өвлийн;

2) Зуны.

e) Хоол бэлтгэлийн:

1) Эрэгтэй;

2) Эмэгтэй.

f) Хоол түгээлтийн:

1) Эрэгтэй;

2) Эмэгтэй.

g) Тусгай зориулалтын:

1) Борооны;

2) Нарны;

3) Бусад.

**6.4.2.2** Галт тэрэгний ажилтны хувцас нь энэ стандартад заасан ангилал тус бүрээр иж бүрэн байх бөгөөд гүйцэтгэх ажлын онцлогт тохирсон, “MNS ISO 13688 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Хамгаалалтын хувцас - Ерөнхий шаардлага” стандартад нийцсэн байна.

**6.4.2.3** Зорчигч үйлчилгээний хувцас нь дараах онцлог шаардлагад нийцсэн байна. Үүнд:

- a) Байгууллагын онцлогийг илэрхийлсэн, ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг бусад байгууллагаас ялгарахуйц хэв шинжтэй байх;
- b) Улирал, цаг агаарын нөхцөл байдалд зохицсон, ажилтны эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан байх.

**6.4.2.4** Тусгай зориулалтын хувцас нь дараах онцлог шаардлагад нийцсэн байна. Үүнд:

- a) Галт тэрэгний хөдөлгөөний болон хөдөлмөрийн аюулгүй байдалд саад учруулахааргүй өнгө, хийцтэй байна;
- b) Борооны хувцас нь бороо, ус үл нэвтрэх материалаар хийгдсэн байна;
- c) Нарны хувцас нь ажилтныг нарны цацраг, хурц гэрэл ба дулааны үйлчлэлээс хамгаалдаг байна.

### **6.4.3 Үндсэн чиг үүргийн ажилтны хувцаслалт, гоо зүйд тавих шаардлага**

**6.4.3.1** Төмөр замын байгууллага нь дор дурдсан ажилтнуудыг дараах хувцсаар хангадаг байна. Үүнд:

- a) Ажил удирдагчийг:
  - 1) Зорчигч үйлчилгээний хувцас;
  - 2) Тусгай зориулалтын хувцас.
- b) Үйлчилгээний ажилтныг:
  - 1) Зорчигч үйлчилгээний хувцас;
  - 2) Тусгай зориулалтын хувцас.
- c) Цэвэрлэгээний ажилтныг: Цэвэрлэгээний хувцас.
- d) Галлагааны ажилтныг: Галлагааны хувцас.
- e) Техникийн ажилтныг:
  - 1) Техник үйлчилгээний хувцас;
  - 2) Тусгай зориулалтын хувцас.
- f) Тээшийн ажилтныг:
  - 1) Техник үйлчилгээний хувцас;
  - 2) Тусгай зориулалтын хувцас.
- g) Тасалбарын ба хяналтын ажилтныг:
  - 1) Зорчигч үйлчилгээний хувцас;
  - 2) Тусгай зориулалтын хувцас.
- h) Зоогийн вагоны ажилтныг:
  - 1) Хоол бэлтгэлийн ажилтнуудыг – хоол бэлтгэлийн хувцас;
  - 2) Танхимын ажилтнуудыг – хоол түгээлтийн хувцас.
- i) Үүргийн худалдаа үйлчилгээний ажилтныг: Хоол түгээлтийн хувцас.
- j) Хамгаалалтын, захиалгат үйлчилгээ хариуцсан болон бусад ажилтан: Ажил үүргийн онцлогт нийцсэн тусгай зориулалтын бусад хувцас.

**6.4.3.2** Нэг ажилтан энэ стандартад заасан хэд хэдэн чиг үүргийг хавсран гүйцэтгэдэг бол төмөр замын байгууллага нь тухайн ажилтныг тэдгээр чиг үүрэг нэг бүрд хамаарах хувцсаар хангана.

**6.4.3.3** Төмөр замын байгууллага нь галт тэрэгний ажилтны хувцсыг хэрэглэх зааврыг энэ стандартад нийцүүлэн тогтоон албажуулж мөрдүүлнэ.

**6.4.3.4** Зорчигч тээврийн байгууллага нь галт тэрэгний ажилтны гоо зүйд хамаарах дараах шаардлагыг хангуулж ажиллана. Үүнд:

- a) Биеийн ил харагдах хэсэгт шивээс хийлгээгүй байна (хөмсөг хамаарахгүй).
- b) Ээмэг хэрэглэх бол унждаг бус, сувдлаг шигтгээтэй байх бөгөөд чих тус бүрд нэгээс илүүгүй тоотой байна.
- c) Цаг, бугуйвч, бөгж, хүзүүний зүүлт хэрэглэх бол энгийн хийцтэй, тус бүр нэгээс олонгүй байх бөгөөд хүзүүний зүүлтний өргөн нь 2 мм-ээс, бөгж, бугуйвчны өргөн нь 5 мм-ээс тус тус ихгүй байна.
- d) Нүдний шил, линз хэрэглэх бол хурц тод өнгийн бус, энгийн хийцтэй байна.
- e) Эмэгтэй ажилтны толгойн үсний суурь өнгө нь хар эсвэл хар хүрэн байх ба байгууллагаас тогтоосон хэм хэмжээнд сорлосон байж болно. Үсний засалт нь энгийн-ажил хэрэгч, ардаа нэг боосон байвал зохино. Хөвсийлгөх, буржийлгах, сүлжих зэрэг илүү хэв маяггүй байна.
- f) Эрэгтэй ажилтны толгойн үс нь хар эсвэл хар хүрэн өнгөтэй байх ба этгээд хэв маяггүй, ажил хэрэгч засалттай байна. Сахал тавих бол тачир хэв маягаар үзэмжтэй засуулсан байна.
- g) Төмөр замын байгууллага нь галт тэрэгний ажилтны хэрэглэх сүрчиг ба энгэсэгт тавих шаардлагыг тодорхойлж мөрдүүлэх ба нэгдсэн журмаар хангах асуудлыг шийдвэрлэсэн байвал зохино.
- h) Галт тэрэгний ажилтан нь хумсыг цэвэрхэн засаж арчилсан байвал зохино. Зайлшгүй шаардлагаар бор шаргал өнгийн лакаар өнгөлөх болон хиймэл хумс хийлгэж болно.

## **7. Зорчигчийн галт тэрэгний аяллын бэлэн байдалд тавих шаардлага**

### **7.1 Техникийн бэлэн байдалд тавих шаардлага**

**7.1.1** Зорчигч тээврийн байгууллага нь зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүний техникийн байдлыг энэ стандартын 5 дугаар зүйлд заасан шаардлагад бүрэн нийцсэн болохыг тус тусын шалгах хуудсаар шалгаж баримтжуулсан байна.

**7.1.2** Төмөр замын байгууллага нь зөвхөн энэ стандартын 7.1.1-д заасан шаардлагад бүрэн нийцсэн галт тэргийг аялуулна.

### **7.2 Үйлчилгээний бэлэн байдалд тавих шаардлага**

**7.2.1** Үйлчилгээний бэлэн байдалд тавих шаардлагад зорчигчийн вагоны зэхэлт, бэлтгэл бүрэн хангагдсан байдлыг авч үзнэ.

**7.2.2** Зорчигчийн вагоны зэхэлтэд тэдгээрийг ус, унд ба дагалдах хэрэгсэл, хүнс, ариун цэврийн багц, цагаан хэрэглэл, зөөлөн эдлэл, хатуу түлш, галлагааны ба угаалга цэвэрлэгээний материал хэрэгсэл зэрэг аяллын үед хэрэглэгдэх нөөцөөр хангах асуудлыг авч үзнэ.

**7.2.3** Зорчигчийн вагоны бэлтгэлд тэдгээрийн гадна дотор угаалга цэвэрлэгээ, халдваргүйтгэл, зэхэлтийн материал хэрэгслийг үйлчилгээнд бэлтгэх болон аялалд бэлтгэх бусад ажилбарыг авч үзнэ.

**7.2.4** Зорчигч тээврийн байгууллага нь үйлчилгээний бэлэн байдлыг энэ стандартын 7.3-т заасан шаардлага нэг бүрийн дагуу шалгах хуудсаар шалгаж баримтжуулсан байна.

**7.2.5** Төмөр замын байгууллага нь үйлчилгээний бэлэн байдал бүрэн хангагдсан

галт тэргийг аялуулна.

### **7.3 Зэхэлтийн материал хэрэгсэлд тавих шаардлага**

#### **7.3.1 Ус**

Зорчигчийн вагоныг зэхэх ундны ус нь “MNS 0900:2018. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” стандартад нийцсэн байна.

#### **7.3.2 Унд ба дагалдах хэрэгсэл**

**7.3.2.1** Зорчигчийн галт тэргэн дэх үйлчилгээнд хэрэглэгдэх унд нь цай, кофе, буцалсан, цэвэршүүлсэн ба эрдэст ус, жүүс, хийжүүлсэн ундааг оролцуулаад 10-аас доошгүй төрлийн сонголттой байна.

**7.3.2.2** Унд ба дагалдах хэрэгслийн үйлдвэрлэгч нь “ISO 9001. Чанарын менежментийн тогтолцоо. Шаардлага” эсвэл “ISO 22000. Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид тавих шаардлага” стандартын шаардлагын дагуу баталгаажсан байгууллага байна.

**7.3.2.3** Унданд хэрэглэх цай кофе нь “MNS 0687-2, Үл согтууруулах ундаа. Цай болон кофены төрлийн ундаа. Техникийн ерөнхий шаардлага”, цэвэршүүлсэн ус нь “MNS 5007. Савласан ус. Техникийн ерөнхий шаардлага”, эрдэст ус нь “MNS 6955:2021. Байгалийн эрдэст ус. Техникийн ерөнхий шаардлага”, жүүс нь “MNS 0687-1. Төрөл бүрийн жимс жимсгэнэ, ногооны шүүс. Техникийн ерөнхий шаардлага”, хийжүүлсэн ундаа нь “MNS 0687-3, Хийжүүлсэн ундаа. Техникийн шаардлага” стандартуудад тус тус нийцсэн байх бөгөөд холбогдох шаардлагад нийцүүлэн хадгалж тээвэрлэнэ.

Зоогийн вагонд дээр дурдсанаас гадна савласан сүү, тараг, бусад органик ундаар үйлчилж болох бөгөөд, тэдгээрийг тус тусын хэрэглэх, хадгалах зааварт чанд нийцүүлэн зэхэх буюу хадгалж тээвэрлэнэ.

**7.3.2.4** Ундны дагалдах хэрэгслийн иж бүрдэл нь сахар, аяга, халбагатай байвал зохино.

**7.3.2.5** Төмөр замын байгууллага нь унд ба дагалдах хэрэгсэл дээр өөрийн болон үйлдвэрлэгчийн барааны тэмдгийг хослуулан байршуулсан байна.

**7.3.2.6** Төмөр замын байгууллага нь унд ба дагалдах хэрэгсэлд тусгай шаардлага тавих бол энэ стандартад нийцүүлэн баталж мөрдөнө.

#### **7.3.3 Хүнс**

**7.3.3.1** Зорчигчийн галт тэрэгний үйлчилгээнд хэрэглэгдэх хүнс нь “MNS ISO 22000:2019. Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд эрхлэгчид тавих шаардлага” стандартын дагуу баталгаажсан үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн байна.

**7.3.3.2** Зорчигчийн галт тэргэнд бэлэн, хагас бэлэн бүтээгдэхүүнээр үйлчлэх бол тэдгээрийг тус тусын хэрэглэх, хадгалах зааварт чанд нийцүүлэн зэхэх буюу хадгалж тээвэрлэнэ.

**7.3.3.3** Зорчигчийн галт тэргэн дэх үйлчилгээнд хагас боловсруулсан махан бүтээгдэхүүн хэрэглэх бол тэдгээр нь “MNS 1804:2006. Хагас боловсруулсан махан бүтээгдэхүүн. Техникийн ерөнхий шаардлага” стандартад нийцсэн байна.

**7.3.3.4** Зорчигчийн галт тэргэн дэх үйлчилгээнд түүхий мах хэрэглэх бол тэдгээрийг нэг удаагийн хэрэглэх нормт хэмжээгээр жижиглэн савлаж, -3°C (цельсийн хасах гурван градус)-аас ихгүй температурт бүрэн хөлдөөсөн байдлаар хадгалж тээвэрлэх бөгөөд зөвхөн хэрэглэхийн өмнө гэсгээнэ. Дахин жижиглэн хувааж хэрэглэх бол гэсгээлгүйгээр хөрөөдөх буюу цавчина.

**7.3.3.5** Аяллын үед хоолыг зөвхөн зоогийн вагонд эсвэл хоол үйлдвэрлэлийн тоноглол бүхий тусгай зориулалтын вагонд “MNS 4946:2019. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага” стандартын холбогдох шаардлагуудад нийцүүлэн үйлдвэрлэнэ.

**7.3.3.6** Төмөр замын байгууллага нь хүнсний зэхэлт, бэлтгэлд тусгай шаардлага тавих бол энэ стандартад нийцүүлэн баталж мөрдүүлнэ.

#### **7.3.4 Ариун цэврийн багц**

**7.3.4.1** Ариун цэврийн багцад аяллын үед зорчигчийн хувийн эрүүл ахуйн наад захын хэрэгцээг хангахад шаардлагатай гарын арчуур, саван, шүдний оо, сойз бусад бүрдлийг авч үзнэ.

**7.3.4.2** Ариун цэврийн багц болон түүний бүрдлийг үйлдвэрлэгч нь “ISO 9001. Чанарын менежментийн тогтолцоо. Шаардлага” стандартын шаардлагын дагуу баталгаажсан байгууллага байна.

**7.3.4.3** Төмөр замын байгууллага нь ариун цэврийн багц дээр өөрийн болон үйлдвэрлэгчийн барааны тэмдгийг хослуулан байршуулсан байна.

**7.3.4.4** Төмөр замын байгууллага нь ариун цэврийн багц, түүний бүрдлүүдэд тавих шаардлагыг энэ стандартад нийцүүлэн баталж мөрдүүлнэ.

#### **7.3.5 Цагаан хэрэглэл**

**7.3.5.1** Зорчигчдод үйлчлэх цагаан хэрэглэлд дэвсгэр ба хучлага даавуу, дэрний уут хамаарна. Цагаан хэрэглэлийн суурь өнгө нь цагаан байх бөгөөд байгууллагын онцлогт нийцсэн хээ, судал, зураглал гэх мэт бусад өнгөний оролцоотой байж болно.

**7.3.5.2** Хучлага ба дэвсгэр даавуу нь дараах хэмжээтэй байна:

- Урт: 220 см ± 5 см;
- Өргөн: 150 см ± 5 см.

**7.3.5.3** Дэрний уут нь дараах хэмжээтэй байна:

- Урт: 60 см ± 5 см;
- Өргөн: 40 см ± 5 см.

**7.3.5.4** Цагаан хэрэглэлийг дараах байдлаар ангилан авч үзнэ. Үүнд:

а) Нэг удаагийн – дахин хэрэглэгдэхгүй;

b) Давтан хэрэглээний, үүнд:

- Тусгай зэрэг – тусгай үйлчилгээнд зориулсан, өндөр чанар бүхий;
- 1-р зэрэг – нийтийн үйлчилгээний, шинэ ба шинэвтэр;
- 2-р зэрэг – нийтийн үйлчилгээний, хуучин;

**7.3.5.5** Нэг удаагийн цагаан хэрэглэл нь энэ стандарт болон олон улсын эсвэл тухайн үйлдвэрлэгч улсын стандартад заасан шаардлагад нийцсэн байна.

**7.3.5.6** Тусгай зэрэглэлийн цагаан хэрэглэлд тавих шаардлагыг төмөр замын байгууллага нь өөрийн үйлчилгээний онцлогт нийцүүлэн тодорхойлж баталж мөрдүүлнэ.

**7.3.5.7** Зорчигч тээврийн байгууллага нь давтан хэрэглээний цагаан хэрэглэлийн суурь өнгөний цайралтыг хэмжиж баримтжуулдаг байх бөгөөд 1-р зэргийн цагаан хэрэглэлд 98%-с дээш цайралттай, 2-р зэргийн цагаан хэрэглэлд 90%-97% цайралттайг тус тус хамааруулан багцалж савлан лацдах бөгөөд, савлагааны уутан дээр тухайн цагаан хэрэглэлийн зэргийг томруунаар тэмдэглэсэн байна.

**7.3.5.8** Зорчигч тээврийн байгууллага нь бие даасан ариун цэврийн багцаар үйлчилдэггүй бол гарын арчуурыг цагаан хэрэглэлийн багцад хамтатган багцалж болно.

**7.3.5.9** Цагаан хэрэглэл нь вагоны зэрэглэлээс хамаарч дараах сонголттой байна. Үүнд:

- a) Дээд зэрэглэл буюу тусгай вагонд: зөвхөн тусгай зэрэг;
- b) Тохилог зэрэглэл буюу зөөлөн вагонд:
  - 1) нэг удаагийн;
  - 2) тусгай зэрэг;
- c) 1-р зэрэглэл буюу тасалгаат вагонд:
  - 1) нэг удаагийн;
  - 2) 1-р зэрэг;
  - 3) 2-р зэрэг;
- d) 2-р зэрэглэл буюу унтлагын вагонд:
  - 1) нэг удаагийн;
  - 2) 2-р зэрэг.

### **7.3.6 Зөөлөн эдлэл**

**7.3.6.1** Зөөлөн эдлэлийг унтлагын ба вагоны гэж ангилан авч үзнэ.

**7.3.6.2** Унтлагын зөөлөн эдлэл нь дараах иж бүрдэлтэй байна. Үүнд:

- a) Гудас;
- b) Дэр;
- c) Дулаан хучлага.

**7.3.6.3** Вагоны зөөлөн эдлэлд зорчигчийн ая тухыг хангахад зориулан зэхэж бэлтгэсэн даавуун хөшиг, бүтээлэг, хивсэнцэр зэрэг нэмэлт хэрэгслийг авч үзнэ.

**7.3.6.4** Төмөр замын байгууллага нь унтлагын ба вагоны зөөлөн эдлэлд тавих шаардлагыг энэ стандартад нийцүүлэн баталж мөрдүүлнэ.



### **7.3.7 Хатуу түлш**

**7.3.7.1** Хатуу түлшинд галлагаат ус буцалгуурт болон зорчигчийн вагоны халаалтад хэрэглэх шатамхай биетийг авч үзнэ.

**7.3.7.2** Ус буцалгуурт түлээний мод хэрэглэх бол зууханд багтах хэмжээгээр жижиглэж бэлтгэсэн, үртсэн болон адилтгах шахмал түлш хэрэглэх бол үйлдвэрийн аргаар дээрх хэмжээгээр бэлтгүүлсэн байна.

**7.3.7.3** Зорчигчийн вагоны халаалтад сайжруулсан шахмал түлш хэрэглэх бол тэдгээр нь “MNS 5679:2022. Сайжруулсан хатуу түлш. Техникийн шаардлага” стандартад нийцсэн, түүхий нүүрс бусад хатуу түлш хэрэглэх бол тэдгээр нь 3500 ккал/кг-аас багагүй илчлэгтэй, нунтаг ба үл шатах хольцын агууламж 10%-аас ихгүй байна. Илчлэгийн дээд хэмжээг халаалтын зуухны онцлогоос хамааруулж зорчигч тээврийн байгууллага тодорхойлж албажуулан мөрдөнө.

### **7.3.8 Галлагааны хэрэгсэл**

**7.3.8.1** Зорчигч тээврийн байгууллага нь галлагааны хэрэгслийг хатуу түлшин халаалттай вагоны тоогоор бэлтгэж, галлагааны улирлын туршид хангана.

**7.3.8.2** Галлагааны хэрэгсэл нь дараах иж бүрдэлтэй байна. Үүнд:

- a) Галын дэгээ;
- b) Үнс нурамны хутгуур;
- c) Төмөр хувин;
- d) Царил.

**7.3.8.3** Зорчигч тээврийн байгууллага нь галлагааны хэрэгсэлд тавих шаардлагыг энэ стандартад нийцүүлэн тодорхойлж хангана.

### **7.3.9 Угаалга цэвэрлэгээний материал, хэрэгсэл**

**7.3.9.1** Угаалга цэвэрлэгээний материал хэрэгсэлд угаалга, цэвэрлэгээ, өнгөлгөө, халдваргүйтгэлийн хатуу, шингэн ба нунтаг бодисууд, цэвэрлэгээний багаж, хэрэгсэл, төхөөрөмжүүд хамаарна.

**7.3.9.2** Төмөр замын байгууллага нь угаалга цэвэрлэгээний материал хэрэгсэлд тавих шаардлагыг энэ стандартад нийцүүлэн тодорхойлж албажуулан мөрдүүлнэ.

### **7.3.10 Анхны тусламжийн иж бүрдэл**

**7.3.10.1** Зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүнд аялах вагон нэг бүр нь анхны тусламжийн (эмнэлгийн) иж бүрдлээр зэхэгдсэн байна.

**7.3.10.2** Анхны тусламжийн иж бүрдэл нь зориулалтын хайрцаг эсвэл цүнхтэй байх бөгөөд хамгийн багадаа дараах материал, хэрэгсэлтэй байна. Үүнд:

- a) Бинт;
- b) Ариун салфетка;
- c) Шархны наалт;
- d) Том хэмжээний наалт;
- e) Резин бээлий;
- f) Халуун хэмжигч;

- g) Халдваргүйтгэх уусмал;
- h) Амнаас аманд хиймэл амьсгал хийхэд хэрэглэх дундаа нүхтэй даавуу эсвэл хуванцар хаалт;
- i) Арьсанд шигдсэн зүйлсийг авах зориулалтын чимхүүр;
- j) Нүдний хүүхэн хараа шалгах бага оврын гар чийдэн;
- k) Жагсаалт ба хэрэглэх заавар.

**7.3.10.3** Анхны тусламжийн иж бүрдэл дэх материал хэрэгсэл нь хадгалалтын горим зөрчигдөөгүй, ашиглалтын хугацаа дуусаагүй бүрэн бүтэн байна.

### **7.3.11 Халдвар хамгааллын хэрэгсэл**

**7.3.11.1** Зорчигчийн галт тэрэг нэг бүр нь нэг удаагийн зориулалттай халдвар хамгааллын хэрэгслээр зэхэгдсэн байна.

**7.3.11.2** Халдвар хамгааллын хэрэгсэл нь “MNS 6853:2020. Эрүүл мэндийн зориулалттай нэг удаагийн халдвар хамгааллын хэрэгсэл. Комбинзон болон гутлын гадуур өмсгөлийн иж бүрдэл. Техникийн шаардлага” стандартад нийцсэн байна.

**7.3.11.3** Зорчигч тээврийн байгууллага нь халдвар хамгааллын хэрэгслийн зэхэлтийн норм, хадгалалт, хэрэглээнд тавих шаардлагыг энэ стандартад нийцүүлэн баталж мөрдөнө.

## **8 Зорчигчийн галт тэрэг, вагон дахь үйлчилгээнд тавих шаардлага**

### **8.1 Ерөнхий шаардлага**

Зорчигч тээврийн байгууллага нь зорчигч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагын судалгааг тогтмол давтамжтайгаар авч дүн шинжилгээ хийдэг байх ба тэдгээрийн үр дүнд суурилан зорчигчийн галт тэрэг, вагон дахь үйлчилгээнд тавих шаардлагыг галт тэрэг, вагоны ангилал, зэрэглэл тус бүрээр энэ стандартад нийцүүлэн тодорхойлж албажуулан мөрдөж ажиллана.

### **8.2 Зорчигч, үйлчлүүлэгчийг угтан авах, үдэн гаргах**

**8.2.1** Зорчигч, үйлчлүүлэгчийг угтан авах, үдэн гаргах үйлчилгээнд дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

- a) Зорчигч, үйлчлүүлэгчийг угтан авч вагонд оруулах, тусламж хүссэн тохиолдолд замчлах;
- b) Суудлаа эзлэх, гар тээшээ байршуулах талаар заавар зөвлөмж өгөх, тусламж хүссэн нөхцөлд туслалцаа үзүүлэх;
- c) Аюулгүй зорчих санамж, зааварчилга өгөх;
- d) Зорчигчдод тэдний буух ба шилжин суух өртөөнд хүрэх цаг, бэлтгэлээ хангах талаар мэдээлэл өгөх;
- e) Зорчигчийг үдэн буулгах, тусламж хүссэн тохиолдолд туслалцаа үзүүлэх.

**8.2.2** Зорчигч тээврийн байгууллага нь зорчигч үйлчлүүлэгчдийг угтан авах, үдэн гаргах үйлчилгээнд тавих шаардлагыг зорчигчийн галт тэрэг, вагон дахь үйлчилгээнд тавих шаардлагын баримт бичигт тусгуулан мөрдөх бөгөөд уг шаардлагад үйлчлүүлэгчтэй харилцах журам, өндөр настан, хөгжлийн болон хөдөлгөөний бэрхшээлтэй, асаргаа шаардлагатай зорчигчдод үйлчлэх асуудлыг

тусгасан байна.

### **8.3 Зорчигчдод үйлчлэх**

**8.3.1** Зорчигчийн галт тэрэгний аяллын үеийн үйлчилгээнд дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

- a) Зорчигчдод үндсэн үйлчилгээ үзүүлэх;
- b) Зорчигчдод нэмэлт үйлчилгээ үзүүлэх;
- c) Зорчигчдод тусгай буюу “VIP” үйлчилгээ үзүүлэх.

**8.3.2** Зорчигч тээврийн байгууллага нь аяллын үеийн үндсэн, нэмэлт ба тусгай үйлчилгээнд тавих шаардлагыг зорчигчийн галт тэрэг, вагон дахь үйлчилгээнд тавих шаардлагын баримт бичигт тусган мөрдөнө.

### **8.4 Зорчигчдын ая тухыг хангах**

**8.4.1** Дээд, тохилог ба 1, 2 дугаар зэрэглэлийн вагоны доторх агаарын температур  $22\pm 2^{\circ}\text{C}$  (цельсийн 20 - 24 градус), 3 дугаар зэрэглэлийн вагоны хувьд  $20\pm 2^{\circ}\text{C}$  (цельсийн 18 - 22 градус) байна.

Төмөр замын байгууллага нь гадна агаарын температур  $+10^{\circ}\text{C}$ -аас бага болсон үед энэхүү шаардлагыг хангах зорилгоор зорчигчийн вагоны халаалтад хатуу түлш хэрэглэж болно.

**8.4.2** Бүх зэрэглэлийн вагоны агаарын найрлага нь “MNS 4585. Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага” стандартад нийцсэн байна.

**8.4.3** Галт тэрэгний ажилтан нар нь зорчигчийн вагоны доторх агаарын температур ба найрлагыг орчны нөлөөллөөс үл хамааран аяллын туршид тогтоосон хэм хэмжээнд байлгана.

### **8.5 Зорчигчийн вагоны аяллын үеийн цэвэрлэгээ, халдваргүйтгэл**

**8.5.1** Зорчигч тээврийн байгууллага нь вагоны доторх цэвэрлэгээ ба халдваргүйтгэлд тавих шаардлагыг Монгол улсын хууль тогтоомжуудад нийцүүлэн баталж мөрдүүлнэ.

**8.5.2** Вагоны доторх цэвэрлэгээ ба халдваргүйтгэлд тавих шаардлагын баримт бичигт дараах асуудлуудыг тусгасан байна. Үүнд:

- a) Хуурай цэвэрлэгээ;
- b) Ундны усаар хангах тоноглолуудын цэвэрлэгээ ба халдваргүйтгэл;
- c) Давтан хэрэглээний сав суулганы цэвэрлэгээ ба халдваргүйтгэл;
- d) Зорчигчийн ширээний цэвэрлэгээ ба халдваргүйтгэл;
- e) Гарын угаалтуур, тосгуурын цэвэрлэгээ ба халдваргүйтгэл;
- f) Ариун цэврийн суултуурын цэвэрлэгээ ба халдваргүйтгэл;
- g) Ариун цэврийн өрөөний шалны цэвэрлэгээ ба халдваргүйтгэл;
- h) Зорчих талбайн (шал, дэвсгэр) цэвэрлэгээ ба халдваргүйтгэл;
- i) Хана, адар тааз, цонх, ор ба суудлын цэвэрлэгээ, халдваргүйтгэл;
- j) Хог хаягдлын ангилан ялгалт ба зайлуулалт.

**8.5.3** Төмөр замын байгууллага нь бохир ус хуримтлуулах сав бүхий ариун цэврийн

байгууламжтай вагонуудын нөөцлүүрийг аяллын явцад суллаж зайлуулдаг байна.












## 8.6 Мэдээллийн үйлчилгээ

### 8.6.1 Тэмдэг тэмдэглэгээ (пиктограмм)

Зорчигч тээврийн байгууллага нь зорчигчийн вагон дахь өрөө тасалгаа, эд юмсын зориулалт ба хэрэглээг 1-р хүснэгтэд заасан зурган тэмдэглэгээний тусламжтайгаар зорчигч, үйлчлүүлэгчдэд мэдээлнэ.

#### 1-р хүснэгт - Зорчигчдод зориулсан зурган тэмдэглэгээ

№	Нэр	Тэмдэглэгээ	Байрлуулах газар
1	Эрэгтэй ариун цэврийн өрөө		165 см өндөрт хаалганы төв хэсэгт эсвэл хаалганы ойролцоо
2	Эмэгтэй ариун цэврийн өрөө		165 см өндөрт хаалганы төв хэсэгт эсвэл хаалганы ойролцоо
3	Дундын ариун цэврийн өрөө		165 см өндөрт хаалганы төв хэсэгт эсвэл хаалганы ойролцоо
4	Ус (уух зориулалтгүй)		Цоргоны дээр
5	Ундны ус		Цоргоны дээр
6	Ариун цэврийн өрөө		165 см өндөрт хаалганы төв хэсэгт эсвэл электрон самбар (табло) дээр
7	Шингэн саван		Шингэн саван гаргах төхөөрөмжийн ойролцоо
8	Шүршүүр		165 см өндөрт хаалганы төв хэсэгт эсвэл хаалганы ойролцоо
9	Сахлын машинд зориулсан розетка		Розетканы дээр
10	Угаалгын өрөө		165 см өндөрт хаалганы төв хэсэгт эсвэл хаалганы ойролцоо

11	Хогны сав		Хайрцган дээр
12	Суултуурт гадны биет бүү хий		Суултуурын дээр
13	Суултуурын ус татах гишгүүр		Ариун цэврийн өрөөнд
14	Ашиглагдахгүй байгаа хаалга		165 см өндөрт хаалганы төв хэсэгт эсвэл хаалганы ойролцоо
15	Шагайхыг хориглоно		Цонхны дээр
16	Цонхоор хог бүү хая		Цонхны дээр
17	Тамхи татахыг хориглоно		Вагоны гонх болон том хонгилын хананд
18	Ресторан		165 см өндөрт хаалганы төв хэсэгт эсвэл хаалганы ойролцоо
19	Буфет		165 см өндөрт хаалганы төв хэсэгт эсвэл хаалганы ойролцоо
20	Галт тэрэг бүрэн зогстол онгойлгож болохгүй		Гонхны хананд, хаалганы ойролцоо
21	Вагоны үйлчлэгчийн амралтын өрөө		165 см өндөрт хаалганы төв хэсэгт эсвэл хаалганы ойролцоо

22	Вагоны үйлчлэгчийн ажлын өрөө		165 см өндөрт хаалганы төв хэсэгт эсвэл хаалганы ойролцоо
23	Зогсоох цорго		Зогсоох цоргоны ойролцоо
24	Цонх-Аврах гарц		Цонхны дээр
25	Тасалгаат вагоны суудлын дугаар		Хаалганы ойролцоо, суудлын ойролцоо
27	Унтлагын болон нийтийн вагоны суудлын дугаар		Суудлын ар хананд
26	Вагоны дугаар		Ажлын болон ажлын бус талын хонгилын хаалганы дээр
27	~220В		Розетканы дээр эсвэл ойролцоо
28	~110В		Розетканы дээр эсвэл ойролцоо
29	- 50В		Розетканы дээр эсвэл ойролцоо
30	Гэрлийн унтраалга		Унтраалганы дээр
31	Дууны түвшин тохируулагч		Дууны түвшин тохируулагчийн дээр
32	Галт тэрэгний радио удирдлагын өрөө		165 см өндөрт хаалганы төв хэсэгт эсвэл хаалганы ойролцоо
33	Анхны тусламжийн хайрцаг		Хайрцаг байрлах хананд
34	Хөгжлийн бэрхшээлтэй зорчигчид зориулсан суудал		Суудлын ойролцоо

35	Хөгжлийн бэрхшээлтэй зорчигчид зориулсан ариун цэврийн өрөө		165 см өндөрт хаалганы төв хэсэгт эсвэл хаалганы ойролцоо
36	Хаалганы түгжих бариулны байрлал заагч		Цоожны дээр эсвэл бариулны ойролцоо
37	Тасалгааны дугаар		165 см өндөрт хаалганы төв хэсэгт эсвэл хаалганы ойролцоо байрлуулна
38	Гар тоормос		Гар тоормосны дээр

### 8.6.2 Ханын самбар, зурагт хуудас

**8.6.2.1** Зорчигчийн вагонд дараах мэдээллийг ханын самбар, зурагт хуудас хэлбэрээр байршуулсан байна. Үүнд:

- Байгууллагын танилцуулга;
- Галт тэрэгний багийн танилцуулга;
- Аяллын цагийн хуваарь;
- Галт тэрэг, вагон дахь үйлчилгээнүүд;
- Зорчигчийн зайлшгүй мэдвэл зохих санамж, анхааруулгууд;
- Бусад мэдээлэл.

**8.6.2.2** Зорчигч тээврийн байгууллага нь ханын самбар, зурагт хуудасны загвар, хэмжээ, тоо, байршил ба агуулгад тавих шаардлагыг тодорхойлж зорчигчийн галт тэрэг, вагон дахь үйлчилгээнд тавих шаардлагын баримт бичигт тусган мөрдөнө.

### 8.6.3 Интернэт ба тоон контентын үйлчилгээ

**8.6.3.1** Төмөр замын байгууллага нь зорчигчийн галт тэрэгний аяллын туршид зорчигчдыг тоон контентын үйлчилгээгээр хангадаг байна.

**8.6.3.2** Төмөр замын байгууллага нь зорчигчийн галт тэргийг интернэт сүлжээгээр хангах асуудлыг түгээгч байгууллагатай хамтран шийдвэрлэсэн байна.

**8.6.3.3** Зорчигч тээврийн байгууллага нь интернэт ба тоон контентын үйлчилгээнд тавих шаардлагыг энэ стандартад нийцүүлэн тодорхойлж зорчигчийн галт тэрэг, вагон дахь үйлчилгээнд тавих шаардлагын баримт бичигт тусган мөрдөнө.

### 8.6.4 Радио, телевизийн нэвтрүүлэг

**8.6.4.1** Зорчигчийн галт тэрэг нь зорчигчдод интернэт ба тоон контентын үйлчилгээ үзүүлдэггүй бол радио, шаардлагатай бол телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээтэй байна.

**8.6.4.2** Зорчигчийн галт тэрэг нь радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээг интернэт ба тоон контентын үйлчилгээтэй хавсран үзүүлдэг байж болно.

**8.6.4.3** Зорчигч тээврийн байгууллага нь радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээнд тавих шаардлагыг энэ стандартад нийцүүлэн тодорхойлж зорчигчийн галт тэрэг, вагон дахь үйлчилгээнд тавих шаардлагын баримт бичигт тусган мөрдөнө.

## **8.7 Вагон рестораны, хүнсний худалдаа үйлчилгээ**

**8.7.1** Алсын аяллын бүх галт тэрэг нь зоогийн вагонтой аялж вагон рестораны үйлчилгээ үзүүлдэг байна.

**8.7.2** Зорчигч тээврийн байгууллага нь хот хоорондын, хот дүүргийн ба бусад ангилал, зэрэглэлийн галт тэргэнд вагон рестораны үйлчилгээ үзүүлэх асуудлыг хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шийдвэрлэнэ.

**8.7.3** Зоогийн вагонгүй галт тэргэнд хүнсний худалдаа үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлдэг байна.

**8.7.4** Вагон рестораны болон хүнсний худалдаа эрхэлж буй байгууллага нь “ISO 22000. Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид тавих шаардлага” стандартын дагуу баталгаажсан байгууллага байна.

## **8.8 Тээш тээвэрлэх үйлчилгээ**

**8.8.1** Төмөр замын байгууллага нь зорчигч, үйлчлүүлэгчдийн тээш, ачаан тээшийг тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн тусгай зориулалтын тээшийн вагоноор тээвэрлэнэ.

**8.8.2** Төмөр замын байгууллага нь олон улсын харилцааны галт тэргэнд тээш тээвэрлэх нөхцөлийг холбогдох гэрээ, хэлэлцээрээр зохицуулсан байна.

**8.8.3** Төмөр замын байгууллага нь зорчигчийн галт тэргээр тээш, ачаан тээш тээвэрлэх үйлчилгээнд тавих шаардлагыг энэ стандартад нийцүүлэн тодорхойлж албажуулан мөрдүүлнэ.

## **8.9 Аяллын үед зорчих тасалбараар үйлчлэх**

**8.9.1** Зорчигч тээврийн байгууллага нь зорчих тасалбаргүй аялж буй үйлчлүүлэгчид аяллын явцад тасалбар худалдаалах үйлчилгээг үзүүлнэ.

**8.9.2** Зорчигч тээврийн байгууллага нь зорчих тасалбар худалдаалалтад тавих шаардлагыг энэ стандартад нийцүүлэн тодорхойлж албажуулан мөрдөнө.



**Ном зүй**

0115-2010 ПКБ ЦЛ. АЛББОМ. Знаки и надписи на пассажирских вагонах, курсирующих в международном сообщении.

ГОСТ 33596–2015, Устройства электронагревательные для систем отопления железнодорожного подвижного состава

ГОСТ Р 54750:2011, Рельсовые автобусы. Общие технические требования

--oOo--